

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 1 ДЭХ
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

№ 11

2018.04.05

Өлгий сум

Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.

Тус Цагдаагийн газар энэ 7 хоногийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 76 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд 19 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.

Мөн 4 гомдол, мэдээлэлд хэрэг нээхээс татгалзсан.

Хулгайлах хэрэг 5, хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг 10, бусад төрлийн 4 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Нийт 169 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 146 хүнд 7,876,000 төгрөгийн тогуулийн шийтгэл оногдуулсан, 5 хүн баривчлагдсан, 28 хүн эрүүлжүүлэгдсэн.

**Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон бусад чиглэлээр
хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.**

Иргэн бүрийн хариуцлагыг дээшлүүлэх, хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд чиглэсэн ухуулга нөлөөллийн “**БИ ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН**” аяны хүрээнд Өлгий сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр нийт 48 хүнд сургалт зохион байгуулсан.

Аяны хүрээнд “Дербес”, орон нутгийн 9 мэдээ радиогоор дамжуулан хариуцлага болон хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэхийн ач холбогдлын талаар 2 минутын мэдээ, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчилж ажилласан.

Гурав: Бусад ажлын талаар:

Цаг агаар дулаарч байгаатай холбогдуулан Цагдаагийн газрын орчин тойронд өдөр бүр цэвэрлэгээ хийж, байгууллагын гадна талын өнгө үзэмжид анхаарч ажиллаж байна.

ЦАГДААГИЙН ГАЗАР